



8. Эдийн засгийн институтын үүрэг аль нь вэ? (1 оноо)  
А. Мэдлэг, соёлыг дамжуулах, бүтээх, өсвөр үеийг нийгэмшүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх  
В. Нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангах, бүлэг болон нийгмийг зохицуулах  
С. Бараа үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэгцээг хангах  
D. Үр удмаа нөхөн үйлдвэрлэх, өсгөж хүмүүжүүлэх  
E. Үл мэдэх ба мэдэж болохгүй зүйлст хариулт өгөх, нийгмийн эв нэгдэл, зөвшилцөл тогтоох
9. Аж үйлдвэржсэн нийгмийн хөгжилд голлох үүрэгтэй нь аль вэ? (1 оноо)  
А. Шашны мяндагт тушаалтнууд, феодалууд  
B. Төрийн удирдагчид  
C. Эрчим хүч, үйлдвэрлэлийн технологи  
D. Эрдэмтэд  
E. Дээрх бүгд
10. Марксизмын үүднээс аль нь ангигүй нийгмийн хэлбэр вэ? (1 оноо)  
А. Феодалын нийгэм  
B. Боолын нийгэм  
C. Хүй нэгдлийн нийгэм  
D. Капиталист нийгэм  
E. Бүгд буруу
11. Нийгмийн амьдралд хамаарахуйц эерэг үр дагаврын тухай шинжлэх ухааны ойлголт аль нь вэ? (2 оноо)  
А. Хамтын нийгэмлэг  
B. Нийгмийн дэвшил  
C. Нийгмийн хувьсгал  
D. Нийгмийн шинэтгэл(реформ)  
E. Нийгмийн өөрчлөлт
12. Нийгмийн . . . . гэдэг үндсэн элемент нь хүмүүс, тэдгээрийн харилцан холбоо, харилцан үйлчлэл, харилцаа болдог бүхэл бүтэн байгууламж юм. (2 оноо)  
А. Харилцан үйлчлэл  
B. Тогтолцоо  
C. Харилцаа  
D. Хурдац  
E. Өсөлт
13. Улс төрийн эрх мэдлийн хэлбэр аль нь вэ? (1 оноо)  
А. Ажил хэрэгч байх  
B. Хариуцлагатай байх  
C. Үүрэг үүсгэх  
D. Эрх эдлэх  
E. Сонголт хийх
14. Улс төр бол “эрх мэдэлд оролцох, түүнийг хуваарилахад нөлөөлөхийн төлөө эрмэлзэн тэмцэх явдал” гэж хэн үзсэн бэ? (1 оноо)  
А. К. Маркс  
B. Р. Даль.  
C. Ф.Бро  
D. Аристотель  
E. М. Вебер
15. Төрийн засаглалын онцлогыг олж тэмдэглэнэ үү? (2 оноо)  
А. Сайн дурын үндсэн дээр, эсхүл аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрөгдсөн улс төр, эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээнүүдээр зохицуулагддаг засаглал  
B. Энэ бол нөлөөлөл, хяналтад тулгуурласан засаглал  
C. Хууль цаазын үндэстэй албадлагын тусгай аппаратад тулгуурладаг, хүн амыг нийтэд нь хамардаг засаглал  
D. Энэ бол улс төрийн намын засаглал  
E. Энэ бол уламжлалт засаглал
16. Улс төрийн тогтолцооний хэм хэмжээ-зохицуулалтын дэд тогтолцооны чиг үүрэгт аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)  
А. Шаардлага дэвшүүлэх  
B. Шаардлагыг шударга шийдвэр болгох  
C. Шийдвэрийг хэрэгжүүлэх үйл явцад оролцох хүмүүсийн үйл байдлыг төлөвшүүлэх  
D. Шашин шүтэх эрх чөлөөг эрхэмлэх  
E. Хуулийг дээдлэх

17. Ерөнхийлөгчийн түр эзгүйд бүрэн эрхийг хэн хэрэгжүүлэх вэ? (1 оноо)  
A. Ерөнхий сайд      B. УИХ дарга      C. Олонхийн суудалтай намын дарга  
D. Үндсэн хуулийн цэцийн дарга      E. Сангийн сайд
18. “Монголын ард түмэн төрийн хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих байгууллагаараа уламжлан эрхээ эдлэнэ” гэсэн Үндсэн хуулийн заалт ардчиллын аль хэлбэрийг илэрхийлж байна вэ? (1 оноо)  
A. Сонгодог ардчилал      B. Шууд ардчилал  
C. Төлөөллийн ардчилал  
D. Оролцооны ардчилал      E. Либерал ардчилал
19. Либерализмын номлолд нийцтэй нь аль вэ? (1 оноо)  
A. Үндэсний үзлийг дээдлэх  
B. Шудрага ёсыг дээдлэх  
C. Эдийн засгийн зохицуулалтыг төр хийх  
D. Хүний эрх, эрх чөлөө, сайн, сайхан байдлыг дээдлэх  
E. Нийгэмд өвлөгдөж ирсэн үнэт зүйлсийг дээдлэх
20. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)  
A. Нам улс төрийн системийн цөм.  
B. Ард түмэн бол улс төрийн системийн цөм  
C. Ардчилал бол улс төрийн системийн цөм  
D. Төр бол улс төрийн системийн цөм  
E. Бүгд зөв
21. Төрийн шинжүүдийг тоочиход аль нь илүүц вэ? (2 оноо)  
A. Нам      B. Хүн ам      C. Нутаг дэвсгэр  
D. Албан татвар      E. Засаг захиргаа
22. УИХ-аар “Ашигт малтмалын тухай хууль”д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн ашигт малтмалын орд газруудын хувьцааны 51 хувь нь төрийн мэдэлд байх ёстой гэсэн заалт оруулжээ. Энэ нь .....болно. (2 оноо)  
A. Шаардлага      B. Дэмжлэг      C. Шийдвэр      D. Орчин      E. Эргэх холбоо
23. Иргэдийн улс төрийн оролцооны хэлбэрүүд аль нь вэ? (2 оноо)  
A. Жагсаал цуглаан      B. Ажил хаялт      C. Сонгууль  
D. Санал, хүсэлт      E. Бүгд
24. Төрийг нийгмийн бусад байгууллагаас ялгах шинж аль нь вэ? (2 оноо)  
A. Нийт нутаг дэвсгэр, хүн амыг бүрэн хамрах  
B. Албадлага хэрэглэх эрхтэй байх  
C. Сүлд, дуулал, далбаатай байх  
D. Татвар авдаг байх  
E. Бүгд зөв
25. Эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд аль нь чухал вэ? (2 оноо)  
A. Эдийн засгийн загваруудын тусламжтайгаар  
B. Улс төрийн бодлогыг харгалзан үзсэнээр  
C. Эдийн засгийн шинжлэх ухааны тусламжтайгаар  
D. Иргэн бүрийн үзэл бодол хийгээд үнэ цэнэтэй баримжааллыг харгалзан үзсэнээр  
E. Бүгд зөв

26. “Яаж- хэнд- юуг” гэсэн асуултад тохирох хариултыг олно уу. (1 оноо)  
A. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо  
B. Холимог эдийн засгийн тогтолцоо  
C. Чөлөөт эдийн засгийн тогтолцоо  
D. Уламжлалт эдийн засгийн тогтолцоо  
E. Эдийн засгийн бүх тогтолцоонд хамаарна
27. Өрсөлдөөний зах зээлд гүйцэтгэх чиг үүргийг тоочихдоо тохирохгүй зүйл дурдсан бол аль нь вэ? (2 оноо)  
A. Баталгаажуулах B. Шалгаруулах C. Бүтээмжийг урамшуулах  
D. Зохицуулах E. Монополь
28. Зах зээлийн үеийн үнийн доорхи төрлүүдээс хамааралгүй нь аль вэ? (2 оноо)  
A. Үйлдвэрийн үнэ B. Бөөний үнэ C. Хөдөлмөрийн үнэ  
D. Жижиглэнгийн үнэ E. Нэрлэсэн үнэ
29. Төрийн өөрийн өмчийн ангилалд аль нь хамааралгүй вэ? (1 оноо)  
A. Төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө  
B. Төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө  
C. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө, төрийн бусад тусгай сан  
D. Газрын хэвлий, түүний баялаг  
E. Төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц
30. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн гол үзүүлэлт аль нь вэ? (2 оноо)  
A. Үндэсний орлого B. Дотоодын нийт бүтээгдэхүүн  
C. Бүтээгдэхүүний өсөлт D. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн E. Бүгд буруу
31. Татвар тооцох, ноогдуулах журамд тохирох нь аль вэ? (1 оноо)  
A. Декларацийн арга B. Кадастрын арга C. Суутгалын арга  
D. Бүгд зөв E. Бүгд буруу
32. Хөдөлмөрийн зах зээлийн үүрэгт хамааралгүй нь аль вэ? (1 оноо)  
A. Ажиллах хүчийг бэлтгэх  
B. Орлогын боломжийг бий болгох  
C. Хөдөлмөрийн нийлүүлэлт  
D. Хөдөлмөрийн эрэлтийг зохицуулах  
E. Банк зээлийн тогтолцоог зохицуулах
33. Орон нутгийн өмчид аль нь хамааралгүй вэ? (1 оноо)  
A. Төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилж шилжүүлсэн өмчлөлийн зүйлс  
B. Өөрийн хөрөнгөөр байгуулсан хуулийн этгээдийн эд хөрөнгө, түүнээс авах ногдол ашиг  
C. Орон нутгийн төсөв, санхүүгийн дэмжлэг, хуульд заасан бусад эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгө  
D. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө, төрийн бусад тусгай сан  
E. Бүгд зөв
34. Соёл үргэлж хөгжиж өөрчлөгдөж байдаг. Гэвч соёл нь өөрийн өвөрмөц шинж чанараа алдалгүй хадгалж үлддэг. Үүнийг соёлын . . . гэж нэрлэдэг. (2 оноо)  
A. Статик шинж B. Динамик шинж C. Нейтраль шинж  
D. Бүгд зөв E. Бүгд буруу

35. Төрийн өмчийг хувьд шилжүүлэх арга аль нь вэ? (1 оноо)  
А. Татан буулгаж эд хөрөнгийг худалдах аргаар хувьчлах  
В. Төрийн эзэмшиж буй хувьцаа, хувь хөрөнгийг худалдах  
С. Уралдаант шалгаруулалт  
D. Дуудлагаар худалдах  
E. Бүгд зөв
36. Өөрийн бүтээгдэхүүнийг тогтвортой хэрэглэх хэрэглэгчтэй болохын тулд хямд үнэтэй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь өрсөлдөөний аль хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)  
А. Борлуулалтын өрсөлдөөн В. Технологийн өрсөлдөөн  
С. Үнийн өрсөлдөөн D. Эрэлтийг бий болгох чадварыг өрсөлдөөн  
E. Аль нь ч биш
37. Доорх бодомжоос давхраажилт гэсэн ойлголттой аль нь хамааралтай вэ? (1 оноо)  
А. Тэгш бус байдлаас янз бүрийн давраа үүсдэг  
В. Тэгш бус байдал ба хязгаарлагдмал нөөцөөс тэнцүү бус хүртэх  
С. Нийгмийн анги, бүлгүүд өмч хөрөнгө, эрх мэдэл, нэр хүндээрээ нэг нь нөгөөгийнхөө доор юм уу дээр байх  
D. Амьжиргааны түвшингөөрөө ялгаатай байх  
E. Бүгд зөв
38. Шилжих хөдөлгөөний хэвтээ хэв маягт аль нь орохгүй вэ? (1 оноо)  
А. Нутаг дэвсгэрийн В. Шашин, сүсэг бишрэлийн С. Гэр бүлийн  
D. Хувь хүний E. Улс төрийн
39. Энэтхэгт кастын 4 хэв маяг байсныг тоочиход илүүц зүйл аль нь вэ? (1 оноо)  
А. Брахман В. Кшатрий С. Войшья D. Чандал E. Шудра
40. Кастын хэв маягийн бусад хэв маягаас ялгагдах онцлогийг олно уу. (1 оноо)  
А. Үе залгамжлуулдаг эрх үүрэгтэй нийгмийн бүлэг  
В. Насан туршдаа өөрчилж болдоггүй нийгмийн бүлэг  
С. Тусгай байранд амьдарч юуг ч өмчилдөггүй, эзний өмч бүлэг  
D. Нийгмийн аж ахуйн тодорхой хэвшилд өөр өөр байр суурь эзэлдгийн улмаас нэг бүлэг хүмүүс нөгөөгийнхөө хөдөлмөрийг завшиж байдаг бүлэг  
E. Бүгд зөв
41. Нийгмийн хамгааллын бодлогын гол зорилго аль нь вэ? (1 оноо)  
А. Ажилгүйдлийг бууруулах  
В. Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх  
С. Цалин нэмэх  
D. Амьжиргааны түвшинг дээшлүүлэх  
E. Соёлын хэрэгцээг хангах
42. Мастер статус аль нь вэ? (1 оноо)  
А. Миний эгч эмч В. Монгол улсын тэргүүн хатагтай Болормаа  
С. Балдан бол инженер D. Би бол оюутан E. Миний ээж халх
43. Шилжих хөдөлгөөний босоо хэв маягт аль нь орох вэ? (1 оноо)  
А. Нутаг дэвсгэрийн В. Бүлгийн С. Гэр бүлийн  
D. Шашин, сүсэг бишрэлийн E. Улс төрийн
44. Нийгэм, нийгмийн бүлэг, хувь хүний хувьд хүлээн зөвшөөрөгдсөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх үйлдэл, объектыг аль элемент илэрхийлэх вэ? (1 оноо)  
А. Хэл В. Мэдлэг С. Бэлгэ тэмдэг D. Шашин шүтлэг E. Итгэл үнэмшил

45. Албан ёсны хэм хэмжээнд аль нь хамааралгүй вэ? (2 оноо)  
A. Үндсэн хууль B. Ерөнхийлөгчийн зарлиг C. Засаг даргын тушаал  
D. Зан заншил E. Бүгд зөв
46. Үнэлэмж хэмээх ойлголтыг илэрхийлэхдээ илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)  
A. Юу зөв, сайныг хүлээн зөвшөөрөх  
B. Хүний мэдрэмж, амьдралын үнэт чиглэл  
C. Олон талт үзэгдэл  
D. Субъектив шинжтэй үзэгдэл  
E. Хоол хүнс
47. Даяаршлын үеийн соёлын бодлогын онцлог юу вэ? (2 оноо)  
A. Соёлын дангааршлыг хангах  
B. Олон янзын соёл мөр зэрэгцэн орших нөхцлийг хангах  
C. Соёлын эрх чөлөө буюу соёлын сонголт хийх нөхцлийг хангах  
D. Дэлхийн дэвшилтэт соёлыг ололтыг дэлгэрүүлэх  
E. Дээрх нөхцлүүдийг харгалзан үзэх
48. Эртний Энэтхэг, Хятадад халбага, сэрээ, хутга, таваг шаазан г.м хоолны хэрэгслүүд үүсэж дэлхийн бусад ард түмнүүдийн зайлшгүй хэрэглээ болсон. Энэ нь соёлын ямар үзэгдэлд хамаарах вэ? (1 оноо)  
A. Соёлын нэвчих B. Соёлын универсаль шинжийн  
C. Соёлын олон талт байдлын D. Бүгд зөв E. Бүгд буруу
49. НҮБ-д гишүүн орнуудад заавал биелүүлэх шийдвэр гаргах эрхтэй ганцхан байгууллага байдаг. Аль нь вэ? (1 оноо)  
A. Олон улсын шүүх B. Аюулгүйн зөвлөл C. Ерөнхий Ассамблей  
D. Нарийн бичгийн дарга нарын газар E. Эдийн засаг, Нийгмийн зөвлөл
50. ЮНИСЕФ хэдэн онд байгуулагдсан бэ? (1 оноо)  
A. 1945 B. 1946 C. 1972 D. 1960 E. 1986
51. Монгол улсын гадаад бодлогын үйл ажиллагааг хамрах салбараар нь зөв ангилсан нь аль вэ? (2 оноо)  
A. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан технологи, соёл хүмүүнлэгийн  
B. Улс төр, эдийн засаг, боловсрол соёлын, хүмүүнлэгийн  
C. Хоёр талын ба олон талт хамтын ажиллагаа  
D. Бүс нутгийн ба тив дамнасан  
E. Бүс нутгийн, олон улсын, тив дамнасан
52. Монгол улсын Төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх бүрэн эрх аль субъектэд хамаардаг вэ? (1 оноо)  
A. УИХ B. Засгийн газар C. Ерөнхийлөгч  
D. Гадаад хэргийн яам E. Дээрх бүгд
53. УИХ-ын гишүүнийг сонгох зарчимд хамааралгүй зүйл аль нь вэ? (2 оноо)  
A. Саналаа нууцаар гаргах B. Чөлөөтэй сонгох  
C. Шууд сонгох  
D. Сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ E. Хүмүүнлэг
54. Хууль, шүүхийн өмнө . . . . тэгш эрхтэй байна. (2 оноо)  
A. Хүн бүр B. Хууль ёсоор оршин суугаа хүн бүр  
C. Монгол улсын иргэн бүр  
D. Бүх хүн E. Эрх зүйн чадамжтай хүн ам

55. Монгол улсын иргэн хүний үндсэн үүрэг аль нь вэ? (1 оноо)  
 А. Хөдөлмөрлөх  
 В. Үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх  
 С. Эрүүл мэндээ хамгаалах  
 D. Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх  
 E. Бүгд зөв
56. УИХ-ын талаарх буруу өгөгдлийг олно уу? (2 оноо)  
 А. Монгол Улсын Хууль тогтоох байгууллагын нэр нь УИХ  
 В. УИХ нь хууль батлан гаргах чиг үүрэгтэй  
 С. Монгол улс нь УИХ-ын тухай хуультай  
 D. УИХ нь Засгийн газраас байгуулагддаг  
 E. УИХ нь байнгын ажиллагаатай парламент мөн

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)  
 (a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- |               |  |
|---------------|--|
| a. М. Вебер   | 1. Нийгэм бол хамтын үйл ажиллагааны өргөн хүрээгээр нэгдмэл, өөрийн удирдлагат ард түмний бүлэг                             |
| b. Т. Парсонс | 2. Нийгэм бол бусад хүмүүс болон үйл явдалд хандсан үйлдлийн үр дүн болдог хүмүүсийн харилцан үйлчлэл                        |
| c. Н.Смелзер  | 3. Нийгэм бол хэл, үнэт зүйлс, хэм хэмжээ бүхий хүмүүсийн хоорондын харилцааны тогтолцоо                                     |
| d. Г. Ленски  | 4. Нийгэм бол тодорхой хил хязгаарт нутаг, хуулийн ерөнхий тогтолцоо, нийгэм- соёлын үндэсний ялгарал бүхий хүмүүсийн нэгдэл |
| e. К. Маркс   | 5. Нийгэм бол ангиудын тэмцлийн бүтээгдэхүүн   |

- 2.2 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)  
 (a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- |                              |   |
|------------------------------|---|
| a. Улс төр<br>(өргөн утгаар) | 1. Нийгмийн зохион байгуулалттай тодорхой хүчнээс хүн амын янз бүрийн бүлгийн харилцаа ба үйл ажиллагаагаар өөртөө учруулах бэрхшээл эсэргүүцлийг даван туулж өөрийн зориг хүслийг эрх зүй, ёс суртахууны зэрэг нийтлэг хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрүүлэх чадвар |
| b. Улс төрийн бодлого        | 2. Төрийн засаглалыг хэрэгжүүлэх, түүнд оролцох, нөлөөлөхийн төлөө нийгмийн бүлгүүдээс явуулж буй үйл ажиллагаа, харилцааны нийлбэр цогц  |
| c. Улс төр<br>(явцуу утгаар) | 3. Албадлагын өвөрмөц аппаратад тулгуурлаж бүх хүн амд хүрч байх улс төрийн засаглалын төвлөрсөн хэлбэр   |
| d. Төрийн засаглал           | 4. Нийгэм дэх шийдвэр гаргах эрх мэдэл, түүнд нөлөөлөх, оролцох, хэрэгжүүлэх үйл явц  |
| e. Улс төрийн засаглал       | 5. Албан ёсны институттэй буюу төр, засгийн институт, орон нутгийн засаг захиргаа зэрэгтэй холбож,  |

- тэдгээрийн хоорондын харилцааны талбар
- 2.3 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)
- (a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- |   |  |
|---|--|
| a. Улс төрийн нам                           | 1. Сөрөг бусад намгүйгээр эрх баригчдын нам дангаар оршин тогтнож төр засгийн эрхийг байнга атгаж байх үеийн намын систем  |
| b. Нэг намын тогтолцоо                      | 2. Парламентдаа олон намууд суудал авсан байх систем   |
| c. Хоёр намын тогтолцоо                     | 3. Засгийн эрхийн төлөө эрмэлзэж, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг тодорхой зохион байгуулалттай нийгмийн институт  |
| d. Олон намын тогтолцоо                     | 4. Нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхолыг илэрхийлж, тэднийг идэвхижүүлэх, нягтруулах чиглэлээр зохион байгуулалтын болон суртал нэвтрүүлгийн үйл ажиллагаа, өөрийн боловсон хүчнийг бэлтгэж, дэвшүүлэх |
| e. Намын улс төрийн системд гүйцэтгэх үүрэг | 5. Төр засгийн төлөөх өрсөлдөөнд хоёр нам байнга давамгайлж, засаг төрийг ээлжлэн барьдаг систем   |

- 2.4 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)
- (a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- |                                 |   |
|---------------------------------|---|
| a. Эдийн засгийн үндсэн асуудал | 1. Эдийн засгийн аль нэг эд эсийг бус бүхэлд нь авч судалдаг ухаан  |
| b. Микро эдийн засаг            | 2. Эдийн засгийг бүхэлд нь бус ганц нэг хэсэгт анхаарлаа хандуулдаг эдийн засгийн судалгааны хэсэг  |
| c. Эдийн засаг                  | 3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэглээг судалдаг ухаан   |
| d. Макро эдийн засаг            | 4. Юу үйлдвэрлэх вэ?, яаж үйлвэрлэх вэ? Хэнд зориулж үйлдвэрлэх вэ? гэдэг асуудал   |
| e. Эдийн засгийн ухаан          | 5. Дуртай тоо хэмжээгээр бэлэн байдаггүй баялаг, үйлчилгээг үйлдвэрлэх, хуваарилах, хэрэглэхтэй холбогдсон бүхий л үйл явцын нийлбэр цогц |